



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/123

Амардалай


Г Сумын гамшгаас хамгаалах удирдлага, Г
ерөнхий мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, удирдлагын бие бүрэлдэхүүн, ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар баталсугай..

Хоёр. Учирч болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, аврах, хор уршгийг арилгах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга (С.Нарантунгалаг)-т үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/123 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ